

“МӨНХИЙН ТОД ЗАМ” ХХК

**Дархан-Уул аймгийн “Од” цогцолбор
сургуулийн “А”, “Б” байрны хатуу
хучилттай авто зам, зогсоолын ажлын
хүрээнд 1:1000-ны масштабтай байр зүйн
зураглалын ажлын тайлан**

Байршил:	Дархан-Уул аймаг , Дархан сум
Планшетийн дугаар:	М-48-92
Захиалагч:	“Мөнхийн тод зам” ХХК
Гүйцэтгэгч:	“Грандмэп Инженеринг” ХХК

Улаанбаатар хот

2023 он

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН “ОД” ЦОГЦОЛБОР СУРГУУЛИЙН
“А”, “Б” БАЙРНЫ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМ,
ЗОГСООЛЫН АЖЛЫН ХҮРЭЭНД 1:1000-НЫ
МАСШТАБТАЙ БАЙР ЗҮЙН ЗУРАГЛАЛЫН АЖЛЫН
ТАЙЛАН

Тайлан бичсэн: Инженер

Д. Мөнхбаяр

Хянасан: Захирал

Г. Рагчаадулам

ЗАХИАЛАГЧ

“МӨНХИЙН ТОД ЗАМ” ХХК

ГҮЙЦЭТГЭГЧ

“ГРАНДМЭП ИНЖЕНЕРИНГ” ХХК




Монгол улс, Улаанбаатар хот,
Хан-Уул дүүрэг, 18-р хороо,
Хүннү 2222 резидент хороолол, 107-902 тоот
Утас: 99024020

И-мэйл: info@grandmapengineering.mn

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН “ОД” ЦОГЦОЛБОР СУРГУУЛИЙН
“А”, “Б” БАЙРНЫ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМ,
ЗОГСООЛЫН АЖЛЫН ХҮРЭЭНД 1:1000-НЫ
МАСШТАБТАЙ БАЙР ЗҮЙН ЗУРАГЛАЛЫН АЖЛЫН
ТАЙЛАН

Тайлан бичсэн:

Инженер



Д. Мөнхбаяр

Хянасан:

Захирал



Г. Рагчаадулам

ЗАХИАЛАГЧ

“МӨНХИЙН ТОД ЗАМ” ХХК

ГҮЙЦЭТГЭГЧ

“ГРАНДМЭП ИНЖЕНЕРИНГ” ХХК



Монгол улс, Улаанбаатар хот,
Хан-Уул дүүрэг, 18-р хороо,
Хүннү 2222 резидент хороолол, 107-902 тоот
Утас: 99024020
И-мэйл: info@grandmapengineering.mn

Гарчиг

1.	ЕРӨНХИЙ ХЭСЭГ	4
1.1.	Оршил	4
1.2.	Ажиллах зарчим	4
1.3.	Ажлын тоо, хэмжээ	5
1.4.	Хамрах хүрээ	5
1.5.	Датум	7
1.6.	Төслийн баг	7
1.7.	Тоног төхөөрөмж	8
2.	СУДАЛГААНЫ ХЭСЭГ	10
2.1	Физик газар зүй, уур амьсгалын онцлог	10
2.2.	Урьд жилүүдэд хийгдсэн ажлын тухайд	11
2.3.	Бэлтгэл ажил	11
3.	Геодезийн цэг, тэмдэгтийн судалгаа	12
4.	Байр зүйн зураглалын хээрийн хэмжилт	14
4.1	1:1000-ны масштабтай байр зүйн зураглал үйлдэх	14
5.	Байр зүйн зураглалын боловсруулалт	15
6.	Хүлээлгэн өгсөн материал	16

Хавсралтууд

Хавсралт 1	Улсын бүртгэлийн гэрчилгээ	20
Хавсралт 2	Тусгай зөвшөөрөл	22
Хавсралт 3	Цэгүүийн хувийн хэрэг	23

Хүснэгтийн дугаарлалт

Хүснэгт 1	Ажлын хэмжээ	5
Хүснэгт 2	Ажил хийж гүйцэтгэсэн огноо	5
Хүснэгт 3	Багийн бүрэлдэхүүн	7
Хүснэгт 4	Ашигласан багажны жагсаалт	8
Хүснэгт 5	Машин техникийн жагсаалт	9
Хүснэгт 6	Судалгаа хийгдсэн цэгүүдийн солбицол, өндөр	12
Хүснэгт 7	Хүлээлгэн өгсөн материал	16

Зургийн дугаарлалт

Зураг 1	Байршлын схем	6
Зураг 2	Зураглал хийсэн талбай	7
Зураг 3	Ашигласан багаж, тоног төхөөрөмж	9
Зураг 4	“12” цэг дээр хайгуул хийсэн байдал	13

Нэр томъёоны тайлбар

GPS	Global Positioning System-Дэлхий нийтийн байрлалын систем буюу хиймэл дагуулын технологиор байрлал тодорхойлох систем
МУ	Монгол улс
GNSS	Global Navigation Satellite System (Дэлхий нийтийн хиймэл дагуулуудын навигацийн систем)
UTM	Universal Transverse Mercator- Дэлхийн хөндлөн меркаторын тусгаг
WGS-84	World Geodetic System- Дэлхий нийтийн геодезийн систем буюу эллипсоид юм
Абрис	Цэгийг хайж олох тойм зураг
EGM08	Earth Gravitational Model- Дэлхийн татах хүчний загвар буюу тайван байгаа далайн төвшнөөр гаргасан геоид загвар
RTK	Real Time Kinematic – Бодит Цагийн Кинематик

1. ЕРӨНХИЙ ХЭСЭГ

1.1. Оршил

“Мөнхийн тод зам” ХХК-тай 2023 оны 10-р сарын 01 нд 16/23 тоот дугаартай Дархан-уул аймгийн “Од” цогцолбор сургуулийн “А”, “Б” байрны хатуу хучилттай авто зам, зогсоолын орчимд байр зүйн зураглалын ажил гүйцэтгэх гэрээг байгуулж гэрээт ажлыг 2023 оны 10-р сарын 26-ноос эхлэн ажиллалаа.

Геодезийн байнгын цэг тэмдэгт суулгах, байрлал өндрийн сүлжээнд холболт хийх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй Газрын тухай, Геодези, Зураг Зүйн тухай болон бусад хууль тогтоомжийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Энэ тайланд Дархан-Уул аймгийн дархан сумын нутагт, “Од” цогцолбор сургуулийн орчимд 1:1000-ны масштабтай 1 метрийн үеийн өндөртэй байр зүйн зургийн ажил, боловсруулалтыг хэрхэн хийсэн талаар бичлээ.

1.2. Ажиллах зарчим

Ажлыг гүйцэтгэхдээ манай компани захиалагч байгууллагаас гаргасан удирдамж, заавар, бэлтгэсэн ажлын аргачлалын дагуу Монгол улсад мөрдөгдөж буй газрын тухай, Геодези зурагзүйн тухай болон бусад хууль тогтоомж, журам стандартын дагуу ажиллана.

Уг ажлыг доорхи техникийн шаардлага, заавар, стандартыг баримтлан гүйцэтгэлээ. Үүнд:

- “Геодезийн байнгын цэг, тэмдэгт байгуулах ажил” БД 11-104-06
- Хиймэл дагуул (GPS/ГЛОНАСС)-ын технологиор монгол улсын геодезийн сүлжээ байгуулах үндсэн дүрэм БнБД 14-101-08
- Монгол улсын засгийн газрын 25-р тогтоол
- Том, дунд масштабтай байр зүйн зураглалд ашиглах Дэлхийн хөндлөн меркатор UTM тусгагийн параметр
- 2014/04/10-ний өдрийн А/112 тушаал
- 2015/02/01-ний өдрийн 1/843 тоот албан бичиг
- “Геодезийн ажлын аюулгүйн техникийн дүрэм” УГЗЗГ, 1976 он
- “1:500-1:5000-ны масштабтай байр зүйн дэвсгэр зураглалын ажил” БД-11-106-08, 2008 он
- Геодези, байр зүйн ажлын техникийн тайлан бичих заавар, 1985
- Ажлын удирдамж

Хээрийн хэмжилтийн үед хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг сахиж, багаж, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг ханган ажиллалаа.

1.3. Ажлын тоо, хэмжээ

Төслийн ажлыг захиалагчийн өгсөн техникийн даалгаврын дагуух тоо хэмжээнд хийж гүйцэтгэлээ.

Хүснэгт 1 . Ажлын хэмжээ


№	АЖЛЫН ТӨРӨЛ, ДАРААЛАЛ	ХЭМЖИХ НЭГЖ	ТОО ХЭМЖЭЭ
1	Геодезийн цэг, тэмдэгтийн судалгаа, сэргээн босголт	цэг	1
2	Байр зүйн зураглалын ажил	га	4,6
3	Байр зүйн зураглалын боловсруулалтын ажил	га	4,6
4	Тайлан бичих	тайлан	1

Хүснэгт 2. Ажил хийж гүйцэтгэсэн огноо


№	АЖЛЫН ТӨРӨЛ, ДАРААЛАЛ	ЭХЭЛСЭН ӨДӨР	ДУУССАН ӨДӨР	ТАЙЛБАР
1	Гэрээ хийсэн	2023/10/01	2023/10/01	
2	Геодезийн цэг, тэмдэгтийн судалгаа, сэргээн босголт	2023/10/26	2023/10/26	
3	Байр зүйн зураглал	2023/10/26	2023/10/27	
4	Байр зүйн зураглалын боловсруулалт	2023/10/27	2023/11/05	
5	Тайлан бичих	2023/10/30	2023/11/10	

1.4. Хамрах хүрээ

Дархан-Уул аймгийн Дархан сум, “Од” цогцолбор сургуулийн орчимд байр зүйн зураглалын ажил хийгдсэн.



Зураг 1. Байршлын схем





Зураг 2. Зураглал хийсэн талбай

1.5. Датум

Байр зүйн зураглал болон сүлжээний ажлыг дараах өгөгдөл ашиглан хийлээ. Үүнд:

Тулгуур эллипсоид:	WGS84
	$a=6378137.0$ /Их хагас тэнхлэг/
	$f=1/298.25722$ /Флатенинг/
Проекц:	6° проекц UTM /зоне 48/
Зохиомол зүүн байрлал:	500'000
Өндрийн систем:	Балтийн тэнгисийн өндрийн тогтолцоо

1.6. Төслийн баг

Төслийн ажлын гүйцэтгэгчээр Грандмэп Инженеринг ХХК ажиллалаа. Төсөлд ажилласан компанийн аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээг хавсралт 1-д, геодези, зураг зүйн үйлдвэр, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг хавсралт 2-д үзүүллээ. Төсөл дээр ажилласан багийн бүрэлдэхүүнийг хүснэгт 3-д үзүүллээ.

Хүснэгт 3. Багийн бүрэлдэхүүн


№	ОВОГ	НЭР	КОМПАНИЙ НЭР	АЛБАН ТУШААЛ
1	Дугарсүрэн	Мөнхбаяр	Грандмэп Инженеринг	(Төслийн ахлагч)
2	Манал	Дашням	Грандмэп Инженеринг	Инженер

1.7. Тоног төхөөрөмж

Төслийн хүрээнд байр зүйн зураглалын ажилд хэрэглэсэн багаж, тоног, төхөөрөмжүүдийг доорх хүснэгт 4-д үзүүллээ.

Хүснэгт 4 . Ашигласан багажны жагсаалт

№	БАГАЖНЫ НЭР	БАГАЖНЫ ТӨРӨЛ	СЕРИАЛ ДУГААР	ТОО ШИРХЭГ
1	TRIMBLE R8-4	GPS	5316434140	1
2	TRIMBLE R8-3	GPS	5030440734	1
3	TRIMBLE R8-2	GPS	4835156437	1
4	Хөл			1
5	Подставка	GPS		1
6	Аккумулятор			1
7	Таяг			2



Зураг 3. Ашигласан багаж, тоног төхөөрөмж

Хүснэгт 5. Машин техникийн жагсаалт

№	МАШИНЫ МАРК	УЛСЫН ДУГААР
1	Тоёота ланд круйзер	22-29 УАМ

2. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

2.1 Физик газар зүй, уур амьсгалын онцлог

Аймгийн түүх

Монгол орны аж үйлдвэрийн томоохон төв Дархан хотын анхны суурийг тухайн үеийн Давхрын төмөр замын өртөө, барилгын түүхий эдийн ордуудыг түшиглэн 1961 оны 10 сарын 17-ны өдөр тавьсан юм.

УИХ-н 1994 оны 32-р тогтоолоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу Дархан хотыг Дархан-Уул аймаг болгон өөрчилсөн. Тус хот нь хуучнаар эдийн засгийн харилцан туслалцах зөвлөлийн гишүүн орнууд болох Зөвлөлт Холбоот Улс, Болгар, Польш, Унгар, Чехословак, Герман зэрэг улсуудын техник, эдийн засгийн хамтын ажиллагааны тусламжтайгаар байгуулагдсан.

Энэ ч утгаараа Дархан хотыг “Найрамдлын хот” хэмээн нэрлэсээр ирсэн.

Газар зүй

Дархан-Уул аймаг нь Монгол орны хойд хэсэгт Хэнтийн нурууны салбар уулсын дунд Хараа голын зүүн хойд хөндийг хамарсан 327.5 мянган га газар нутагтай. Нийт газар нутгийн 70.7 хувь буюу 231.7 мянган га газрыг ХАА-н эдэлбэр газар эдэлдэг.

Тус аймгийн газар нутгийн хэмжээ бага боловч алт, шохойн чулуу, нүүрс, барилгын материалын төрөл бүрийн түүхий эд зэрэг байгалийн баялгийн нөөц ихтэй.

Далайн түвшнээс 707 метрт өргөгдсөн харьцангуй нам дор газар байрлана. Тус аймгийн нутгаар Хэнтийн нуруунаас эх авч цутгадаг Хараа, Зулзага, Шарын гол, Орхон, Ерөө, Хүйтний, Хавчуун зэрэг голууд урсдаг.

Агаарын үнэмлэхүй их температур 7-р сард 42.6 хэм, үнэмлэхүй бага температур нь 1-р сард -43.7 хэм хүрдэг.

Хүн ам, нийгэм

Аймгийн төв Дархан хот нь Монгол улсын томоохон аж үйлдвэрийн төв юм. Дэд бүтэц сайн хөгжсөн, Улаанбаатар-Алтанбулагийн чиглэлийн олон улсын авто зам, Улаанбаатар-Сүхбаатарын төмөр замын зангилаан дээр оршдог, төвийн эрчим хүчний системд холбогдсон, өндөр хурдны шилэн кабель, тоон системийн радио релейний шугам, хөдөлгөөнт холбооны үйлчилгээтэй, бусад аймагтай харьцуулбал нийтийн найдвартай, тогтмол хямд тээврийн хэрэгсэлтэй, хүмүүсийн амьдралын өртөг бага зэрэг давуу талтай. Нийт 91093 хүн амтай, үүнээс 74526 хүн Дархан хотод амьдардаг. Нийт хүн амын 64.5 хувийг 35 хүртэлх насны залуус эзэлнэ. Аймгийн хэмжээнд 24989 өрх байгаагийн 67.5 хувь нь нийтийн орон сууцанд амьдардаг.

Засаг захиргааны нэгжийн хувьд Дархан, Орхон, Хонгор, Шарын гол гэсэн 4 сум, 26 багтай.

2.2. Урьд жилүүдэд хийгдсэн ажлын тухайд

1942 онд Монгол улсын нийт нутаг дэвсгэрийг 1:100'000-ны масштабтай байр зүйн зураглалаар зурагжуулж, 1970 онд шинэчлэл хийж, аналог хэлбэрээр хэвлэсэн. Өмнөговь аймгийн Ханбогд сумын хэмжээнд том масштабтай зураг байхгүй харин дунд масштабын хамгийн сайн зураг нь энэхүү 1:100'000-ны масштабтай байр зүйн зураг байна.

2007 онд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Кадастрын зураглал ба газрын бүртгэл төслийн хүрээнд “Геосет” ХХК, Геокад ХХК 1:1000-ны масштабтай байр зүйн зураглалын ажил хийж гүйцэтгэсэн.

2014 онд “1-1000-ны масштабтай байр зүйн зураглалын шинэчлэлт, тодруулалт”-ын ажлын хүрээнд Дархан-Уул аймгийн Дархан сумын төвийн байр зүйн зураглалыг “Дирекцион” ХХК шинэчлэсэн байна. Геодезийн цэг тэмдэгтүүдийг шинэ эринд бодож тодорхойлсон.

2.3. Бэлтгэл ажил

Хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл, ажлын багаж тоног төхөөрөмжийг Улаанбаатар хотод бэлтгэлээ.

3. Геодезийн цэг, тэмдэгтийн судалгаа

Дархан хотын зүүн урд талд байрлах цэргийн ангийн ар талын толгой дээр байрлах 12 дугаартай цэгийн судалгаа, сэргээн босголтын ажлыг хийлээ.. Судалгаа хийсэн цэгийн солбицол болон өндрийг хүснэгт 6-д үзүүлээ.

Хүснэгт 6 . Судалгаа хийгдсэн цэгүүдийн солбицол, өндөр

№	Цэгийн нэр	Y	X	ӨНДӨР
1	12	571394.994	5479333.120	740.761

Цэг тэмдэгтийн судалгааны ажлыг 10-р сарын 26-нд Грандмэп Инженеринг ХХК-ийн инженер Д. Мөнхбаяр, М. Дашням нар цэгийг газар дээр нь явж судалсан.

Судалгаа хийсэн цэгүүдийн зургуудыг хол болон ойр байдлаас авч, байр зүйн зурагт ашиглагдах цэгүүд дээр хэмжилтийн ажил хийж, цэг тэмдэгтийн хувийн хэргийг бэлдлээ.





Зураг 4. “12” цэг дээр хайгуул хийсэн байдал

4. Байр зүйн зураглалын хээрийн хэмжилт

4.1 1:1000-ны масштабтай байр зүйн зураглал үйлдэх

Байр зүйн зураглалын ажлыг байрлалын хувьд UTM солбицлын тогтолцоо, WGS84 эллипсоид, түүний их тэнхлэгийн хагас 6378137м, түүний шахцал 1:298.257223563-ийг ашиглах ба Балтийн тэнгисийн өндрийн тогтолцоонд хийлээ.

1:1000-ны масштабтай, 1 метрийн үеийн өндөртэй зураглалын ажлыг Trimble фирмийн R8 төрлийн багажуудын RTK аргаар инженер Д. Мөнхбаяр, М. Дашням, нар 2023 оны 10-р сарын 26-наас 27-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

Хэмжилт хийж байгаа багажуудад өндрийн засвар буюу EGM2008 геоид моделиг тохируулсан.

Хэмжилт хийгдсэн талбай маань хороолол доторхи зам байсан учраас байшин барилга, хайс, хашаа, мод, явган зам, газар доорх инженерийн байгууламжийн худаг, тоглоомын талбай зэрэг байрилга байгууламж ихтэй талбай байлаа. Өндөр барилга байгууламжийн ойр GPS-ийн долгион хязгаарлагдаж хэмжилт хийх боломжгүй хэсэг Лейка фирмийн 805 төрлийн электрон тахеометр ашиглан зураглалын ажлыг хийлээ. Объектуудын хэмжилт хийхдээ хэмжилтийн цэгээ кодолж хэмжсэн.

Хэмжилтийн нарийвчлалыг БНБД 11-06-08 зааварт зааснаас ихгүй байхаар хийж гүйцэтгэсэн.

5. Байр зүйн зураглалын боловсруулалт

4,6 орчим га байр зүйн зургийн суурин боловсруулалтын ажлыг 2023 оны 10-р сарын 27-ноос 2023 оны 11-р сарын 05-ны хооронд хийж гүйцэтгэлээ. 4,6 орчим га байр зүйн зураглалын боловсруулалтын ажил хийлээ.

RTK хэмжилтээр хэмжсэн хэмжилтийн өгөгдлийг LisCAD 12.0 программ дээр цэг тус бүр дээр кодолсон өгөгдлийг ашиглаж холбож зурах болон таних тэмдгээр зурсан. Таних тэмдгээр зурсан өгөгдлийг ашиглан гурвалжин ашиглан хаяалбар татсан. Буруу холбогдсон гурвалжнуудыг засварлаж хаяалбарыг зассан. Хаяалбарын утгыг үндсэн хаяалбар 1 метрээр, тодотгосон хаяалбарыг 5 метр тутам байхаар бодож AutoCAD программ уруу хөрвүүлсэн. Хэмжилтийн өгөгдөл бүрэн дууссаны дараа AutoCAD программ уруу хөрвүүлсэн.

1:1000-ны байр зүйн зураглалыг тоон байдлаар 2 янзаар бэлдсэн. Үүнд:

- 3D байдлаар буюу байр зүйн зургийн элементүүдийг зөв давхаргад оруулсан хэмжилтийн бүх өгөгдлийг өндөртэй таних тэмдгээр зураагүй байх
- 2D байдлаар буюу бүх хэмжилтийг өндрийн утгагүй хэвлэлийн эх бэлдэх байдлаар

Зурагдах объектуудыг ангилал бүрээр нь тус тусад нь өөр өөр давхаргатай оруулсан бөгөөд давхаргын нэр нь объектын ангиллын дугаар байна. Объектын ангиллын дугаар бүхий давхаргыг (My layer) шинээр үүсгэхдээ Color>White, Linetype>Continuous, Lineweight>Default байдлаар сонгосон. Давхаргын нэрсийг хавсралт 9-т харууллаа.

Давхаргыг хийж гүйцэтгэхдээ 1:500-1-5000-ны масштабтай байр зүйн зургийн томьёолсон тэмдэг зааврын дагуу хийж гүйцэтгэсэн.

6. Хүлээлгэн өгсөн материал

Хүснэгт 7 . Хүлээлгэн өгсөн материал

Актаар хүлээлгэж өгөх материалын нэр	Хувь
<ul style="list-style-type: none"> Ажлын нэгдсэн тайлан (монгол, англи хэл дээр) CD дээр бичсэн хуулбар 	1
<ul style="list-style-type: none"> Ажлын нэгдсэн тайлан (монгол, англи хэл дээр) хэвлэмэл байдлаар 	1
<ul style="list-style-type: none"> 1:1000-ны масштабтай байр зүйн зураг DWG файл 	1
Ажил хүлээлгэн өгсөн акт	2

Тайлан бичсэн:

Д. Мөнхбаяр

УБ-2

Монгол Улсын Засгийн газрын
2004 оны 20 дугаар тогтоолоор батлав.



МОНГОЛ УЛС УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

0000094340

2015.01.19

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

9011529037

/ Улсын бүртгэлийн дугаар /

5922054

/ Регистрийн дугаар /

Грандмэп инженеринг

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр

/ шийдвэрийн нэр /

01

/ дугаар /

2015.01.16

/ он, сар, өдөр /

4610

/ код /

Гадаад худалдаа

/ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

/ код /

/ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

/ хугацаа /

1

/ гишүүдийн тоо /

1,000.00

/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Хан-Уул, 15-р хороо, рапид харш. махатма ганди, 27. 148 тоот, Утас1: 99024020, Утас2: .
Факс.

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /



Улсын бүртгэлийн ерөнхий
газрын Бүртгэлийн газар

/ бүртгэсэн байгууллагын нэр /

Харилцах дансны бүртгэл

Харилцагч банкны нэр	Дансны төрөл	Дансны дугаар	Бүртгэсэн ажилтан тэмдэг
Худалдаа хөгжлийн банк	Төгрөгийн	409038122	Д.Чулуунтуяа

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Гомбосүрэн овогтой Рагчаадулам-а Захирал-р томилсныг бүртгэв.	2015.01.19	Д.Чулуунтуяа

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.





БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
ТУСТАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар: 2022/04/18/020

Монгол улсын Геодези, зураг зүйн тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиудын холбогдох заалтыг үндэслэн “ГРАНДМЭП ИНЖЕНЕРИНГ” ХХК /5922054/-д “Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийг 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрөөс 3 жилийн хугацаатай олгов.

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ нь гэрээний хамт хүчинтэй.

САЙД

Б.МӨНХБААТАР

Улаанбаатар хот
2022 он

**ГЕОДЕЗИЙН БАЙНГЫН ЦЭГ ТЭМДЭГТИЙН
ХУВИЙН ХЭРЭГ**

1

1.	Цэгийн нэр	12	2.	Төвийн дугаар	
3.	Трапецийн дугаар (1:100000)	M-48-92	4.	Сүлжээний төрөл	Зураглалын
5.	Байршил (аймаг, сум, дүүрэг, хороо)	Дархан-Уул аймаг, Дархан сум			
		Газарзүйн солбицол		Тэгш өнцөгтийн солбицол	
6.	Солбицол	N49°27'44.8"	E105°59'07.0"	X=571395	Y=5479333

7. Цэгийн гэрэл зураг

ХОЛООС	ойроос
	

8. Байршлын тухай тэмдэглэл: Дархан сумын зүүн урд хэсэгт цэгийн ангийн хойд талын үүрэн холбооны антентай толгой дээр овооны баруун талд 3 метрт байрлана.

9. Байршлын тойм зураг	10. Төв цэгийн хэлбэр
	

11. а. Судалгаа б. Шинээр суулгасан
(өмнөх дугаарыг дугуйлна)

12. Огноо: 2023.10.05

13. Хувийн хэрэг хөтөлсөн:

Инженер: Д. Мөнхбаяр
(албан тушаал, нэр)

Байгууллага:

“Грандмэп Инженеринг” ХХК